



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/249

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 2.3, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.8, 5.1.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, газрын доройтол, цөлжилтийг сааруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлуудыг эрчимжүүлэх үүднээс "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын хүрээнд Дэрэн суманд хаврын улиралд мод тарих үйл ажиллагааны зардлын санхүүжилт болон Аймгийн төвд тарих төлөвлөгөөт газрын нүх, шуудуу ухах ажлын техникийн хөлсөнд шаардагдах зардлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн "Дундговьо ногооруулъя" төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100500

Аймгийн Засаг даргын 2022 оны 05
дугаар сарын 26-ны өдрийн 1249
дугаар захирамжийн хавсралт

“ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
СУМДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Зураг төсвийн нэр	Санхүүжилт
1	Дэрэн суманд хаврын улиралд мод тарих үйл ажиллагааны зардлын санхүүжилт	2,000,000
2	Аймгийн төвд тарих төлөвлөгөөт газрын нүх, шуудуу ухах ажлын техникийн хөлс	1,000,000
Дүн		3,000,000